



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар Б/34

Мөрөн сум

**Ц.Цогбатыг хөгжмийн багшаар
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 47 дугаар зүйлийн 47.1, 49.1, 49.2 дахь заалт, 2024 оны 238 дүгээр тогтоолын 09 дүгээр хавсралт, 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.(Цэвэгмэдийн Цогбат)-ыг 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс хөгжмийн багшаар ажиллуулсугай.

2.Соёлын төвийн хөгжмийн багш (Ц.Цогбат)-ын үндсэн цалинг 2024 оны 238 дүгээр тогтоолын 09 дүгээр хавсралтаар ТҮСБ-ын 1414000 (нэг сая дөрвөн зуун арван дөрвөн мянга)-н төгрөгөөр тогтоосугай.

3.Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтыг үндэслэн орон нутагт ажилласны нэмэгдэл 40 хувийн нэмэгдэл, төрийн алба хаасны нэмэгдлийг хууль, журмын дагуу нэмж олгосугай.

4.Хөгжмийн багш (Ц.Цогбат)-ын цалинг зохих хууль журмын дагуу бодож олгохыг нягтлан бодогч (С.Энхсүх)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ЦЭНДБАЯР